




ДУНДГОВЬ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН
ХЭЛТЭС

ДУНДГОВЬ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН БАЙДАЛ 2023 ОН



www.1212.mn



Дундговь аймаг
2024 он



ГАРЧИГ

1. ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ.....	3
2. ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ.....	4
3. ХӨДӨЛМӨРИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	9
4. АЖИЛЛАГЧИД.....	10
5. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТ.....	11
6. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД.....	15

ЗУРАГ

ЗУРАГ 1. 15, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ОРОЛЦОО

ЗУРАГ 2. АЖИЛЛАХ ХҮЧ, АЖИЛЛАГЧИД . сүүлийн жилүүдээр

ЗУРАГ 3. АЖИЛЛАГЧДЫН ТОО, хүйсээр

ЗУРАГ 4. АЖИЛЛАГЧДЫН ТОО, НАСНЫ БҮЛГЭЭР , эзлэх хувиар

ЗУРАГ 5. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, аймгуудаар

ЗУРАГ 6. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, аймгуудаар

ЗУРАГ 7. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, сүүлийн жилүүдээр

ЗУРАГ 8. ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТЫН ТҮВШИН, сүүлийн 4 жилээр

ЗУРАГ 9. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД, насны ангиллаар

ЗУРАГ 10. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД, төрийн албаны ангиллаар

ХҮСНЭГТ

ХҮСНЭГТ1. ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

ХҮСНЭГТ2. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ЗАХ ЗЭЭЛ

ХҮСНЭГТ 3. ТӨВИЙН БҮСИЙН АЙМГУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

ХҮСНЭГТ 4. АЖИЛЛАГЧДЫН ТОО, ЭДИЙН ЗАСГИЙН САЛБАРЫН АНГИЛЛААР

ХҮСНЭГТ 5. АЖИЛЛАГЧДЫН ТОО, НАСНЫ БҮЛГЭЭР

ХҮСНЭГТ 6. ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТ

ХҮСНЭГТ 7. ТӨВИЙН БҮСИЙН АЙМГУУДЫН АЖИЛГҮЙДЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

ХҮСНЭГТ 8. АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД/үйл ажиллагааны нэгжээр/

ХҮСНЭГТ 9. АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД/үйл ажиллагааны салбараар/



ЗОРИЛГО, АЧ ХОЛБОГДОЛ

Хөдөлмөрийн статистикийн мэдээллийг бий болгох зорилго нь хөдөлмөрийн зах зээлийн хэмжээ, бүтэц, тэдгээрт гарч буй өөрчлөлтийг тодорхойлох, дүн шинжилгээ хийхэд ашигладаг тоон мэдээллийн багцыг бий болгоход оршино.

Энэхүү аргачлалыг мөрдлөг болгосноор хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдлын талаарх илүү нарийвчилсан мэдээлэл, түүнчлэн хөдөлмөрийн дутуу ашиглалтыг бүрэн харуулах статистикийн үзүүлэлтийг бий болгож, бодлого боловсруулагчдыг зохих мэдээллээр хангахад оршино.

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол улсын Статистикийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 6-д “ статистикийн үзүүлэлт, арга зүй нь олон улсын статистикийн стандарт, арга зүйтэй нийцсэн байх”, 12-р зүйлийн 7-д статистикийн үзүүлэлт аргачлалыг олон улсын ангилал, аргачлал, стандартын жишигт нийцүүлэн гаргаж мөрдүүлэх гэж заасан, мөн Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 3.3.2 дахь зорилтын 2 дахь арга хэмжээнд “Хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний статистик ” үзүүлэлтийг тооцох аргачлалыг шинэчлэх гэж тус тус заасан нь энэхүү аргачлалыг боловсруулах хууль эрх зүйн үндэс юм.

2019 оноос эхлэн шинэ аргачлал, ойлголт тодорхойлолтын дагуу явуулж байна. Олон улсын хөдөлмөрийн статистикийн 2013 онд болсон 19-р бага хурлаар 1982 оны 13-р бага хурлаас баталсан аргачлал нь хөдөлмөрийн зах зээлийн бодит дүр зургийг төдийлөн илэрхийлж чадахгүй, хөдөлмөр эрхлэлтийн бодлогыг тодорхойлоход дутагдалтай байгааг онцолж, аргачлалыг шинэчлэх шийдвэр гаргасан юм.

Маш хурдацтай өөрчлөгдөж буй хөдөлмөрийн зах зээлийн нөхцөл байдлыг бодитоор харуулахын тулд бид олон улсын шинэ аргачлалыг өөрийн орны онцлогт тусган нэвтрүүлж, Үндэсний Статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А-09/08 тоот хамтарсан тушаалаар “Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох шинэчилсэн аргачлал”-ыг батлан 2019 оны 1 дүгээр сараас эхлэн мөрдөж байна.

Хөдөлмөрийн статистикчдийн олон улсын 19-р бага хурлын “Ажил, хөдөлмөр эрхлэлт, ажиллах хүчний дутуу ашиглалт”-ын талаарх тогтоолын дагуу хөдөлмөрийн статистикийн ойлголт, аргачлалд гарсан томоохон өөрчлөлтийг дурдвал:

Цалин хөлс, орлого олох зорилгоор ажиллаж буй ажиллагчдын тодорхойлолт, үзүүлэлтийг сайжруулсан (Ингэснээр бусад төрлийн ажил, тухайлбал, өөрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл явуулж буй хүмүүс, цалингүй дадлагажигч ажилтан, сайн дурын ажилтан зэргийг ажиллагчдаас ялгах боломжтой болж байгаа юм).

Хөдөлмөрийн насны хүн амыг 15 ба түүнээс дээш насаар тогтоосон.

Ажиллагчдын үндсэн ажлын шалгуур нь хуучнаар хамгийн их цалин хөлс, орлого олдог ажил нь байсан бол шинэ аргачлалын дагуу цалин, орлогоос үл хамааран хамгийн их цаг зарцуулдаг ажлыг үндсэн ажил гэж тодорхойлсон.

Ажилгүй хүний шалгуур шинэчлэгдэн, цалин хөлс, орлого олох ажилгүй, сүүлийн 30 хоногт ажил идэвхтэй хайсан болон тухайн 7 хоногтоо ажил хийхэд бэлэн байгаа гэсэн 3 шалгуурыг хангасан хүнийг хэлэх болсон. Өмнө нь “сүүлийн 2 шалгуурын аль нэгийг нь хангах” гэж авч үзэж байсан. Мөн насны дээд хязгааргүй болсон.

- Ажиллах хүчний дутуу ашиглалтыг хэмжих уламжлалт үзүүлэлт буюу ажилгүй хүн, ажилгүйдлийн түвшнээс илүү өргөн хүрээний хөдөлмөрийн дутуу ашиглалт, түүний түвшнүүд бүхий шинэ үзүүлэлтүүдийг бий болгосон.



ОЙЛГОЛТ, ТОДОРХОЙЛОЛТ

Үндэсний Статистикийн хорооны дарга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2019 оны А- 09/08 тоот хамтарсан тушаалаар батлагдсан "Хөдөлмөр эрхлэлтийн статистикийн үзүүлэлтийг тооцох шинэчилсэн аргачлал"-ыг 2019 оны 1 дүгээр сараас мөрдөж байна. Үүнтэй уялдуулан хөдөлмөрийн статистикийн үндсэн үзүүлэлтийн мэдээллийн гол эх үүсвэр болох Ажиллах хүчний судалгааг шинэ ойлголт тодорхойлолт, аргачлалын дагуу явуулж байна.

Хөдөлмөрийн насны хүн ам гэж 15, түүнээс дээш насны хүн амыг хэлнэ. Хөдөлмөрийн насны хүн амыг ажиллах хүч болон ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж ангилна (заалт 15, 65, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

Ажиллах хүч гэж тухайн хугацаанд зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэхэд хүч хөдөлмөрөө нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүн юм (заалт 11, 16, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

Ажиллах хүчнээс гадуурх хүн ам гэж сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр настан, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, хөгжлийн бэрхшээлтэй болон ажил хайх итгэл алдарсан зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллах хүчинд хамаарахгүй хөдөлмөрийн насны хүн амыг ойлгоно. Ажиллах хүчнээс гадуурх хүн амаас энэ боломжит ажиллах хүчийг тодорхойлно. Мөн ажиллах хүч болон боломжит ажиллах хүч хоёрын нийлбэрээр өргөтгөсөн ажиллах хүч илэрхийлэгдэнэ (заалт 16,55, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

Ажиллагч гэж зөвхөн хөдөлмөр эрхлэлтийн ажлын хэлбэрийн хүрээнд, цалин хөлс, орлого олох зорилгоор бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж буй хөдөлмөрийн насны хүнийг хэлнэ. Хөдөлмөр эрхлэгчдийг ажлын байрандаа байгаа болон түр эзгүй байгаа гэж хоёр бүлэгт хувааж авч үзнэ (заалт 27, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол-1).

Хөдөлмөр эрхлэлтийн статус гэж эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж байгаа тухайн ажиллагчийг ажиллаж байгаа эдийн засгийн нэгж (хувь хүн, аж ахуйн нэгж, байгууллага эсэх) болон эрх мэдэл, ажил үүргээр нь ангилахыг ойлгоно.

Ажил олгогч гэж ашиг олох зорилгоор тогтмол хугацаанд нэг буюу түүнээс дээш хүнийг "цалин хөлстэй ажиллагч"-аар ажиллуулдаг хувиараа хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийг ойлгоно. Цалин хөлсөөр ажиллаж буй ажиллагч гэдэгт ажлын байрандаа түр эзгүй байгаа ажиллагчийг оруулна, харин үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг хамтран гаргадаг бизнесийн хамтрагч болон өрхийн бусад туслагчдыг оруулахгүй. Ажил олгогчдыг дотор нь аж ахуйн нэгж байгууллагын ажил олгогч (захирал, менежер) болон өрхийн зах зээлийн аж ахуйн нэгжийн ажил олгогч гэж хоёр ангилна.

Аж ахуйн нэгж, байгууллагын ажил олгогч гэж ашиг олох зорилгоор аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг бие даан эсвэл нэг болон хэд хэдэн хувь нийлүүлэгч бүхий бизнесийн хамтрагчтайгаа хамтран эрхэлж, тухайн үйл ажиллагаандаа нэг буюу түүнээс дээш хүнийг тогтмол "цалин хөлстэй ажиллагч"-аар ажиллуулан, хувийн бизнесийнхээ үйл ажиллагаанд оролцуулж байгаа байгууллагын эзэн бүхий ажиллагч юм. Цалин хөлсөөр ажиллаж буй ажиллагчид ажлын байрандаа түр эзгүй байгаа ажиллагчийг оруулна, харин



үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг хамтран гаргадаг бизнесийн хамтрагч болон өрхийн бусад туслагчдыг оруулахгүй.

Зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажил олгогч гэж ашиг олох зорилгоор аж ахуйн нэгж байгууллага бус зах зээлийн аж ахуйн нэгжийг бие даан эсвэл нэг болон хэд хэдэн хувь нийлүүлэгч бүхий бизнесийн хамтрагчтайгаа хамтран эрхэлж, тухайн үйл ажиллагаандаа нэг буюу түүнээс дээш хүнийг тогтмол “цалин хөлстэй ажиллагч”- аар ажиллуулж байгаа ажиллагч юм. Цалин хөлсөөр ажиллаж буй ажиллагчид ажлын байрандаа түр эзгүй байгаа ажиллагчийг оруулна, харин үйл ажиллагаатай холбоотой шийдвэрийг хамтран гаргадаг бизнесийн хамтрагч болон өрхийн бусад туслагчдыг оруулахгүй.

Цалин хөлстэй ажилтангүй бие даасан ажиллагч гэж өөрийн хөрөнгөөрөө бие даан, эсвэл бусадтай хамтран эдийн засгийн үйл ажиллагаа эрхэлж, тухайн хугацаанд ямар нэгэн цалин хөлстэй ажилтан авч ажиллуулаагүй хувиараа хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийг ойлгоно. Ямар нэгэн цалин хөлстэй ажилтан авч ажиллуулаагүй гэдэг нь өөрөөсөө, бизнесийн хамтрагч, хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүнээсээ өөр нэг ч хүн ажилчнаар авч ажиллуулаагүй байхыг ойлгоно. Эдгээр хөдөлмөр эрхлэгчдийг дотор нь цалин хөлстэй ажилтангүй аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаа эрхлэгч болон цалин хөлстэй ажиллагчгүй зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч гэж хоёр ангилна. Цалин хөлстэй ажилтангүй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа эрхлэгч гэж ямар нэгэн цалин хөлстэй ажилтан авч ажиллуулахгүйгээр, бие даан эсвэл хувь эзэмшигч, бизнесийн хамтрагч, хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүдтэйгээ хамтран аж ахуйн нэгж, байгууллагын (хязгаарлагдмал хариуцлагатай компани, нөхөрлөл, хоршоо) үйл ажиллагааг эрхэлж буй ажилч юм.

Цалин хөлстэй ажилтангүй, зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн үйл ажиллагаа эрхлэгч гэж ямар нэгэн цалин хөлстэй ажилтан авч ажиллуулахгүйгээр, бие даан эсвэл бизнесийн хамтрагч, хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүдтэйгээ хамтран аж ахуйн нэгж байгууллага бус зах зээлийн аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг эрхэлж явуулдаг ажилч юм.

Гүйцэтгэх гэрээлэгч гэж эдийн засгийн өөр нэг нэгжид, эсвэл уг нэгжээр дамжуулаад бүтээгдэхүүн, үйлчилгээг нийлүүлэх зорилгоор арилжааны шинжтэй гэрээ (хөдөлмөрийн бус) байгуулан ажиллаж буй ажиллагч юм. Эдгээр ажиллагч нь тухайн эдийн засгийн нэгжийн цалин хөлстэй ажиллагч биш боловч ажлын төлөвлөлт, зохион байгуулалт, гүйцэтгэл, орлого болон зах зээлд гарах боломж зэрэг нь уг эдийн засгийн нэгжээс хамаардаг. Мөн эдгээр ажиллагч нь тэдний үйлдвэрлэлийн (бүтээмжтэй) үйл ажиллагаанд хяналт тавьж, хийж гүйцэтгэсэн ажлынх нь үр шимийг шууд хүртдэг эдийн засгийн өөр нэгжээс хараат, ашгийн төлөө ажиллагч юм.

Цалин хөлстэй ажиллагч гэж ажиллаж буй эдийн засгийн нэгжээ эзэмшдэггүй, үйл ажиллагааны шийдвэрт оролцохгүйгээр тухайн нэгжид албан болон албан бусаар хөдөлмөр эрхлэн, ажилласан цаг, хийж гүйцэтгэсэн ажлынхаа (зарим тохиолдолд хийж гүйцэтгэсэн ажлынхаа үйл ажиллагаа тус бүрд) эсвэл худалдаа, үйлчилгээ (тоо хэмээ, захиалгын тоогоор) үзүүлснийхээ төлбөр болгон мөнгөн болон мөнгөн бус хэлбэрээр цалин хөлс авдаг ажиллагч юм. Цалинтай ажиллагчдыг хөдөлмөр эрхлэлтийн гэрээний нөхцөл, хөдөлмөрийн харилцааны зохицуулалтаас нь хамаарч 4 ангилна.

Цалин хөлстэй байнгын ажиллагч гэж ажлын цагийн доод хэмжээгээр ажиллах нь хүлээн зөвшөөрөгдсөн, байнгын буюу тухайн эдийн засгийн нэгжид ажиллах насны дээд хязгаар,



тэтгэвэрт гарах нас зэргээс бусад хөдөлмөр эрхлэлтийг зогсоох тодорхой хугацаа, нөхцөл заагдаагүйгээр хөдөлмөр эрхэлдэг ажиллагч юм. Эдгээр ажиллагчид нь албан болон албан бус ажлын байранд бүтэн эсвэл хагас цагаар ажиллагч байж болно. Мөн ажилд ороод удаагүй, туршилтын хугацаандаа ажиллаж байгаа боловч цаашид үргэлжлүүлээд байнгын хугацаагаар ажиллуулахаар хүлээгдэж байгаа ажиллагч орно.

Цалин хөлстэй түр ажиллагч гэж хөдөлмөр эрхлэх хугацаа нь 3 ба түүнээс дээш сараар хязгаарлагдсан буюу тодорхой хугацаатай хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм. Эдгээр ажиллагчид нь албан болон албан бус ажлын байранд бүтэн эсвэл хагас цагаар ажиллагч байж болно.

Цалин хөлстэй тохиолдлын ажиллагч гэж ажлын тогтсон цаггүй, хөдөлмөр эрхлэлт нь 3 сар хүртэлх хугацаагаар хязгаарлагдсан буюу богино хугацаатай хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм.

Цалин хөлстэй дагалдан ажилтан, мэргэшиж буй дадлагажигч ажилтан, дагалдан дадлагажигчид гэж цалин хөлстэйгөөр, ажлын байрны болон мэргэжлийн хувьд дадлага, туршлага, ур чадвар эзэмших зорилгоор бусдын хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, үйлчилгээ үзүүлж буй ажиллагч юм.

Хувь нэмрээ оруулагч гэр бүлийн гишүүн гэж өрхийн гишүүд, мөн өөр өрхөд амьдарч буй гэр бүлийн холбоотой (эцэг, эх, ах, дүү гэх мэт) хүмүүсийн эрхэлж буй зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажилд, эсвэл тэдгээрийн цалинтай ажил болон гүйцэтгэх гэрээлэгчээр ажиллаж буй ажилд нь тусалж байгаа ажиллагчийг хэлнэ. Тэд эдийн засгийн нэгжийн үйл ажиллагаанд нь нөлөөлөх шийдвэр гаргадаггүй, үүрэг хүлээдэггүй бөгөөд цалин хөлсгүйгээр оролцож, үйл ажиллагаанаас олсон орлогоос өрх дотроо ашиг хүртдэг. Хөдөлмөрийн дутуу ашиглалт гэж хөдөлмөрийн нийлүүлэлт болон эрэлтийн зөрүү буюу хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байхыг ойлгоно (заалт 40, 42 ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол). Хөдөлмөрийн дутуу ашиглалтыг дараах үзүүлэлтээр хэмжинэ. Үүнд:

Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч гэж тухайн хугацаанд хөдөлмөр эрхэлж буй ажиллагчийн бүх ажлынх нь ажлын цаг нь үндэсний хууль тогтоомжид заасан босго цагаас бага бөгөөд өөр ажил хийх хүсэлтэй, нэмэлт цагаар ажиллахад бэлэн байгаа хүнийг ойлгоно. Босго цаг гэдгийг Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу 7 хоногийн ажлын 40 цагаар авч үзнэ (заалт 43 ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол).

Ажилгүй хүн гэж сүүлийн 7 хоногт хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөр эрхлэх зорилгоор ажил хайж байгаа болон ажил хийхэд бэлэн байгаа хөдөлмөрийн насны хүн юм (заалт 47 ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол).

а. хөдөлмөр эрхлээгүй гэж тухайн хугацаанд буюу сүүлийн 7 хоногт цалин хөлс, орлого олох зорилгоор ямар нэгэн ажил хийгээгүй, ажиллагч гэдэг тодорхойлолтод хамаарахгүй байхыг;

б. ажил хийхэд бэлэн гэж тухайн хугацаанд буюу сүүлийн 7 хоногт эсвэл тухайн хугацаанаас хойш ирэх хоёр долоо хоногт ажил хийж эхлэхэд бэлэн байхыг;

в. ажил хайж байгаа гэж сүүлийн дөрвөн долоо хоногт цалин хөлс, орлого олох зорилгоор ямар нэгэн хэлбэрээр ажил хайсан эсвэл хувийн бизнес эхлүүлэх оролдлого хийсэн хүн юм. Ажил хайх гэдгийг ажилд зуучлах төрийн болон хувийн байгууллагад бүртгүүлэх, ажлын байрны талаар мэдээлэл авч ажил олгогчтой холбогдсон, ажлын зар, цахим хуудсаар ажил олгогчид хандах, нийтийн үйлчилгээний газруудын мэдээллийн самбар, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд зар тавих гэх мэт ажил олох оролдлого идэвхтэй хийхийг



ойлгоно. Харин ажлын байрны талаар мэдээлэл авсан ч ажил олгогчид хандаагүй бол идэвхтэй оролдлого хийсэн гэж үзэхгүй.

Боломжит ажиллах хүч гэж цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхлэхийг сонирхож байгаа боловч тодорхой нөхцөл байдлын улмаас ажил хайх оролдлого нь хязгаарлагдсан эсвэл шууд ажил хийх боломжгүй байгаа, тухайн хугацаанд хөдөлмөр эрхлээгүй хүн юм (заалт 40с, 51, ХСОУ-ын 19-р бага хурлын тогтоол). Боломжит ажиллах хүчинд дараах хүмүүсийг хамааруулна. Үүнд:

- а. Ажил хийхэд бэлэн биш байгаа ажил хайгч буюу ажил хайх оролдлого хийж байсан ч тухайн хугацаанд ажил хийхэд бэлэн биш, боломжгүй байгаа хүн;
- б. Ажил хайгаагүй ч ажил хийх боломжтой хүн буюу ажил хайх оролдлого хийгээгүй ч ажил хийх хүсэлтэй, ажил хийхэд бэлэн байгаа хүн.

ТООЦОХ АРГАЧЛАЛ

Ажиллах хүч: Тухайн хугацаанд хөдөлмөрийн зах зээлд ажиллах хүчээ нийлүүлж байгаа ажиллагчид болон нийлүүлэхэд бэлэн байгаа ажилгүй хүний тооны нийлбэрээр тооцно.

$$\text{Ажиллах хүч} = \text{Ажиллагчид} + \text{Ажилгүй хүн}$$

Өргөтгөсөн ажиллах хүч: Ажиллах хүч болон боломжит ажиллах хүчний тооны нийлбэрээр тооцно.

$$\text{Өргөтгөсөн ажиллах хүч} = \text{Ажиллах хүч} + \text{Боломжит ажиллах хүч}$$

Ажиллах хүчний оролцооны түвшин: Ажиллах хүчний тоог хөдөлмөрийн насны хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{Ажиллах хүчний оролцооны түвшин} = \frac{\text{Ажиллах хүч}}{\text{Хөдөлмөрийн насны хүн ам}} * 100\%$$

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин: Ажиллагчдын тоог хөдөлмөрийн хүн амын тоонд харьцуулж тооцно.

$$\text{Хөдөлмөр эрхлэлтийн түвшин} = \frac{\text{Ажиллагчид}}{\text{Хөдөлмөрийн насны хүн ам}} * 100\%$$

Хөдөлмөрийн дутуу ашиглалтын түвшин:

Ажилгүйдлийн түвшин: Ажилгүй хүний тоог ажиллах хүчний тоонд харьцуулж тооцно (ХДАТ-1)

$$\text{ХДАТ 1} = \frac{\text{Ажилгүй хүн}}{\text{Ажиллах хүч}} * 100\%$$

Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин: Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгчид болон ажилгүй хүний тооны нийлбэрийг ажиллах хүчний тоонд харьцуулж тооцно (ХДАТ-2).

$$\text{ХДАТ 2} = \frac{\text{Ажилгүй хүн} + \text{ЦХХББХЭ}}{\text{Ажиллах хүч}} * 100\%$$



Ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин: Боломжит ажиллах хүч болон ажилгүй хүний тооны нийлбэрийг өргөтгөсөн ажиллах хүчний тоонд харьцуулж тооцно (ХДАТ-3).

$$\text{ХДАТ 3} = \frac{\text{Ажилгүй хүн} + \text{Боломжит ажиллах хүч}}{\text{Өргөтгөсөн ажиллах хүч}} * 100$$

Хөдөлмөрийн дутуу ашиглалтын нийлмэл түвшин: Хөдөлмөрийн дутуу ашиглалт буюу ажилгүй хүн, цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч болон боломжит ажиллах хүчний тооны нийлбэрийг өргөтгөсөн ажиллах хүчний тоонд харьцуулж тооцно (ХДАТ-4).

$$\text{ХДАТ 4} = \frac{\text{Ажилгүй хүн} + \text{ЦХХББХЭ} + \text{Боломжит ажиллах хүч}}{\text{Өргөтгөсөн ажиллах хүч}} * 100\%$$

**ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ ХҮН АМЫН ХӨДӨЛМӨРИЙН
ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ОРОЛЦОО**

Ажиллах хүчний судалгааны 2023 оны жилийн эцсийн дүнгээр аймгийн хэмжээнд хөдөлмөрийн насны буюу 15 түүнээс дээш насны 28.1 мянган хүн байгаагийн 13.1 (46.6%) мянга нь эрэгтэй, 15.0 (53.4%) мянга нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн насны хүн ам өмнөх оны мөн үеэс 6.2 мянган (18.2%) хүнээр буурсан байна.

ЗУРАГ 1. 15, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ОРОЛЦОО,




Хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөрийн зах зээлд дэх оролцоог авч үзэхэд, 17.8 (63.1%) мянга нь ажиллах хүч, 10.4 (36.9%) мянга нь ажиллах хүчнээс гадуурх хүн ам байна. Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад ажиллах хүч 7.2(28.8%) мянгаар буурч , ажиллах хүчнээс гадуурх хүн ам 0.9(9.7%) мянгаар өссөн байна.

Ажиллах хүчний 16.6(93.6%) мянга нь цалин хөлс, орлого олох зорилгоор хөдөлмөр эрхэлж байгаа ажиллагчид, 1.1(6.4%) мянга нь хөдөлмөрийн дутуу ашиглалтын нэг бүлэг болох ажилгүй хүн (цалин хөлс, орлого олох ажилгүй, сүүлийн 30 хоногт ажил идэвхтэй хайсан болон тухайн 7 хоногтоо ажил хийхэд бэлэн байгаа хүн) байна.

Харин ажиллах хүчнээс гадуурх хүн амын 0.2 (2.2%) мянга нь боломжит ажиллах хүч (цалин хөлс, орлого олох ажилгүй, сүүлийн 30 хоногт ажил идэвхтэй хайсан эсвэл тухайн 7 хоногтоо ажил хийхэд бэлэн байгаа хүн) байна. Боломжит ажиллах хүчний бүлэг нь тухайн сум, орон нутагт нь ажлын байр бий болох эсвэл ажил хийх нөхцөл нь бүрдвэл хөдөлмөрийн зах зээлд идэвхтэй оролцож эхлэх, ажиллах хүчний эгнээнд шилжихэд бэлэн байгаа хүн ам юм. Энэ утгаараа ажиллах хүчинд ороход боломжит бүлэг гэж үзэн, ажиллах хүчин дээр нэмж өргөн утгаар нь өргөтгөсөн ажиллах хүч гэж авч үздэг.

Ажиллах хүч өмнөх оны мөн үеэс 7.2(28.8%) мянгаар, ажиллагчид 7.0(29.8%) мянгаар, ажилгүй хүн 0.1(9.8%) мянгаар буурсан байна.

ЗУРАГ 2. АЖИЛЛАХ ХҮЧ, АЖИЛЛАГЧИД . сүүлийн жилүүдээр




АЖИЛЛАГЧИД

Ажиллах хүчний судалгаа нь хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулах зорилготой билээ.

Судалгааны үр дүнгээр 2023 онд 16.6 мянган хүн ажил эрхэлж байна энэ нь өмнөх оноос 7.0(29.8%) мянган хүнээр буурсан байна.


Аймгийн ажиллагчдын 7.5(45.3%) мянга нь эрэгтэйчүүд, 9.1(54.7%) мянга нь эмэгтэйчүүд байна.

ЗУРАГ 3. АЖИЛЛАГЧДЫН ТОО,хувиар ,хүйсээр



Нийт ажиллагчдын 1.3 хувийг 15-19 насныхан, 6.1 хувийг 20-24 насныхан, 7.6 хувийг 25-29 насныхан, 9.9 хувийг 30-34 насныхан, 14.4 хувийг 35-39 насныхан, 16.4 хувийг 40-44 насныхан, 20.2 хувийг 45-49 насныхан, 9.9 хувийг 50-54 насныхан, 10.1 хувийг 55-59 насныхан, 3.9 хувийг 60-аас дээш насныхан, эзэлж байна.

ЗУРАГ 4. АЖИЛЛАГЧДЫН ТОО, НАСНЫ БҮЛГЭЭР , эзлэх хувиар




Нийт ажиллагчдын 36.1 хувийг хөдөө аж ахуйн салбарт, 3.5 хувийг уул уурхай, олборлолт, 3.8 хувийг боловсруулах салбарт, 1.6 хувийг барилгын салбарт, 4.8 хувийг цахилгаан, дулаан эрчим хүчний салбарт, 5.7 хувийг бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 2.5 хувийг зочид буудал, зоогийн газрын салбарт, 1.8 хувийг тээвэр холбооны салбарт, 2.1 хувийг санхүү болон даатгалын үйл ажиллагааны салбарт, 10.9 хувийг төрийн удирдлага батлан хамгаалахын салбарт, 14.6 хувийг боловсролын салбарт, 4.7 хувийг эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбарт, 7.9 хувийг бусад салбарт ажиллагсад тус тус эзэлж байна. (ХҮСНЭГТ 4)

АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН


2023 онд аймгийн ажилгүйдлийн түвшин 6.4 болж, өмнөх оноос 1.4 нэгж хувиар өсөж, төвийн бүсийн дунджаас 0.5 нэгж хувиар их, бүсийн хувьд Дархан-Уул аймаг өндөр буюу 12.4 хувь, Төв аймагт ажилгүйдлийн түвшин 1.4 хувьтай гарсан нь хамгийн бага байна. Судалгааны үр дүнгээр ажилгүй иргэдийн тоо 1132 болж, өмнөх оноос 124(9.9%) хүнээр буурсан. Төвийн бүсийн ажилгүй иргэдийг улсын дүнтэй харьцуулахад 0.5 нэгж хувиар их байна.

ЗУРАГ 5. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, аймгуудаар



Ажилгүйдлийн түвшний улсын дүн 5.4, төвийн бүсийн дүн 5.9 байна. Аймгийн дүн 6.4 байгаа нь улсын дүнгээс 1.0 нэгж хувиар, бүсийн дүнгээс 0.5 нэгж хувиар их байна. Ажилгүйдлийн нэгж хувиар хамгийн өндөр нь Дархан-Уул аймаг 12.4, хамгийн бага нь Төв аймаг хамгийн бага 1.4 байна.

ЗУРАГ 6. АЖИЛГҮЙДЛИЙН ТҮВШИН, сүүлийн жилүүдээр



Манай аймгийн хувьд ажилгүйдлийн түвшин өмнөх оноос 1.4 нэгж хувиар өссөн үзүүлэлттэй байна.


АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН

Ажиллах хүчний оролцооны түвшин нь хөдөлмөрийн насны хүн амын хэдэн хувийг ажиллах хүчин эзэлж байгааг харуулдаг үзүүлэлт юм. Мөн хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн байдал, эдийн засагт хөдөлмөрийн насны хүн амыг ажлын байраар хангах зорилтын хэрэгжилтийг хянах хэмжүүр болдог. Ажиллах хүчний тоог хөдөлмөрийн насны хүн амд харьцуулж ажиллах хүчний оролцооны түвшин (АХОТ) тооцно.

Аймгийн ажиллах хүчний оролцооны түвшин нь 2023 онд 63.1 хувь байна. Энэ нь хөдөлмөрийн насны 100 хүн тутмын 63 нь ажил хийж байгаа болон ажил хийхийг хүсэж байгаа хүмүүс байна. Энэ үзүүлэлт өмнөх оноос 9.4 нэгж хувиар буурсан нь хөдөлмөрийн насны хүн амын дотор ажиллагчид болон ажил идэвхтэй хайж байгаа иргэд буурсныг харуулж байна.

Улсын ажиллах хүчний оролцооны түвшин 57.6 хувь байгаагаас манай аймаг 5.5 нэгж хувиар их байна. Өмнөх оны мөн үеэс 9.4 нэгж хувиар өссөн байна.

ЗУРАГ 7. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ОРОЛЦООНЫ ТҮВШИН, аймгуудаар



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН ТҮВШИН

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин нь хөдөлмөрийн насны хүн амын хэдэн хувийг ажиллагчид эзэлж байгааг харуулдаг үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт манай аймгийн хувьд 2023 онд 59.0 болж, өмнөх оноос 9.8 нэгж хувиар буурсан байна. Хөдөлмөрийн насны 100 хүн тутмын 59 нь ямар нэгэн ажил эрхэлж байгааг харуулсан үзүүлэлт юм.(ХҮСНЭГТ 2)

Төвийн бүсийн аймгуудын ажиллах хүч нь улсын дүнд харьцуулахад 14.1 хувь, төвийн бүсдээ 3.2 хувийг Говь-Сүмбэр аймаг, 16.9 хувийг Дархан-уул аймаг, 17.6 хувийг Дорноговь аймаг, 19.2 хувийг Өмнөговь аймаг, 11.1 хувийг Сэлэнгэ аймаг, 22.1 хувийг Төв аймаг, 9.8 хувийг Дундговь аймаг эзэлж байна.

Ажиллах хүчнээс гадуурх хүн амын улсын дүнгийн 13.4 хувийг төвийн бүс, төвийн бүсдээ 4.2 хувийг Говь-Сүмбэр аймаг, 23.6 хувийг Дархан-уул аймаг, 13.7 хувийг Дорноговь аймаг, 11.9 хувийг Өмнөговь аймаг, 26.3 хувийг Сэлэнгэ аймаг, 12.0 хувийг Төв аймаг, 8.2 хувийг Дундговь аймаг эзэлж байна.(ХҮСНЭГТ 3)

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ, ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТ

Хөдөлмөрийн дутуу ашиглалт гэж хөдөлмөрийн нийлүүлэлт болон эрэлтийн зөрүү буюу хөдөлмөрийн насны хүн амын хөдөлмөр эрхлэлтийн хэрэгцээ хангагдахгүй байхыг ойлгоно.


Хөдөлмөрийн дутуу ашиглалт = Ажилгүй хүн + Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч + Боломжит ажиллах хүч

Тайлбар: Хөдөлмөрийн статистикийн үндсэн үзүүлэлтүүдийг мэдээллийн эх үүсвэр нь Ажиллах хүчний судалгаа. Судалгааны үр дүнг улс, аймаг, нийслэлийн түвшинд насны бүлэг, хүйс, эдийн засгийн ангилал, хөдөлмөр эрхлэлтийн статус гэх мэт дэд ангиллаар тооцоход цөөн тооны зөрүү гардаг.

Дундговь аймгийн хувьд хөдөлмөрийн дутуу ашиглалт өмнөх оны мөн үеэс 481(25.6%) хүнээр, боломжит ажиллах хүч 352(60.8%) хүнээр, ажилгүй хүн 124(9.9%) хүнээр, цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч 6(13.3%) хүнээр буурсан үзүүлэлттэй байна.

Хөдөлмөр эрхлэлтийн түвшин нь хөдөлмөрийн насны хүн амын хэдэн хувийг ажиллагчид эзэлж байгааг харуулдаг үзүүлэлт юм. Дундговь аймгийн хувьд хөдөлмөр эрхлэлтийн түвшин өмнөх оны мөн үеэс 9.8 нэгж хувиар 59.0 болж буурсан.

ЗУРАГ 8. ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТЫН ТҮВШИН/сүүлийн 4 жилээр/



Хөдөлмөрийн дутуу ашиглалтын түвшин өмнөх оны мөн үеэс 0.4 нэгж хувиар, ажилгүйдлийн түвшин 1.4 нэгж хувиар, цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэлт болон ажилгүйдлийн нэгдсэн түвшин 1.0 нэгж хувиар, ажилгүй хүн болон боломжит ажиллах хүчний нэгдсэн түвшин 0.4 нэгж хувиар өссөн байна.

Албан бус хөдөлмөр эрхлэгч гэж ажлын байранд хөдөлмөр эрхэлж буй ажиллагч юм. Албан бус хөдөлмөр эрхлэгчид дараах хүмүүсийг хамааруулна. Үүнд: а. Тухайн хугацаанд хөдөлмөрийн харилцаа нь хууль эрх зүйн хүрээнд бүрэн зохицуулагдаагүй, орлогын албан татвар, өвчтэй байсны тэтгэмж, ээлжийн амралт олгодоггүй, нийгмийн хамгааллын бусад асуудал хангагдаагүй нөхцөлд ажиллаж буй цалин хөлстэй ажиллагч;

- б. Албан бус салбарт ажиллаж буй зах зээлд чиглэсэн өрхийн аж ахуйн нэгжийн ажил олгогч болон цалин хөлстэй ажиллагчгүй бие даасан ажиллагч;
- г. Зөвхөн өөрийн эцсийн хэрэглээнд зориулан бүтээгдэхүүн үйлдвэрлэж буй өрхөд цалин хөлстэй ажиллагч;
- д. Хувь нэмэр оруулагч гэр бүлийн гишүүд орно


2023 оны эцсийн байдлаар албан бус хөдөлмөр эрхлэгчид өмнөх оны мөн үеэс ХАА-н салбарт орсон нь 421(2.5%) хүнээр, ХАА-н бус салбарт 170(16.4%) хүнээр өссөн байна. Үүнээс эрэгтэй хүмүүс ХАА-н салбарт 59 хувь, ХАА-н бус салбарт 63.7% хувийг эзэлж байна.

Албан бус хөдөлмөр эрхлэгчид өмнөх оны мөн үеэс хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилтын салбарт 9868(62.2%) хүнээр, барилгын салбарт 10(7.9) хүнээр, бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээний салбарт 219(5125%) хүнээр, үйлчилгээний бусад үйл ажиллагааны салбарт 82(32.4) хүнээр, уул уурхай, олборлолтын салбарт 71(71 дахин) хүнээр буурсан бол боловсруулах үйлдвэрлэлийн салбарт 87(45.7%) хүнээр, тээвэр ба агуулахын үйл ажиллагаа 70(2.2 дахин) хүнээр, зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ 313(6.4 дахин) хүнээр өссөн үзүүлэлттэй байна.


ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД

Дундговь аймгийн нийт төрийн албан хаагчид 3329 байгаагийн 899(27.0%) нь эрэгтэй, 2430(73.0%) нь эмэгтэй албан хаагчид байна. Насны ангиллаар авч үзвэл, 15-24хүртэл насныхан 7.0 хувь, 25-34 насныхан 31.0 хувь, 34-44 насныхан 29.0 хувь, 45-54 насныхан 24.0 хувь, 55-59 насныхан 7.0 хувь, 60, түүнээс дээш насныхан 2.0 хувийг эзэлж байна.

ЗУРАГ 9. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД, насны ангиллаар



ЗУРАГ 10. ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД, төрийн албаны ангиллаар



Нийт төрийн албан хаагчийн 2758(83.0%) нь төрийн үйлчилгээний албан хаагч, 414(12.0%) нь төрийн захиргааны албан хаагч, 119(4.0%) нь улс төрийн албан хаагч, 38(1.0%) төрийн тусгай албан хаагч байна.



ХҮСНЭГТҮҮД

ХҮСНЭГТ 1. ХҮН АМЫН АЖИЛ ЭРХЛЭЛТ

Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023
Ажиллах хүч	23 185	22 159	23 309	24 930	17 755
Ажиллагчид	22 040	21 463	21 966	23 674	16 623
Ажилгүй иргэд	1 147	696	1 343	1 256	1 132
Ажиллах хүчнээс гадуурх хүн ам	7 814	9 371	9 261	9 479	10 396

ХҮСНЭГТ 2. АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ЗАХ ЗЭЭЛ

Үзүүлэлт	2019	2020	2021	2022	2023
Ажиллах хүчний оролцооны түвшин	74.8	70.3	71.5	72.5	63.1
Хөдөлмөр эрхлэлтийн түвшин	71.1	68.1	66.3	68.8	59.0
Ажилгүйдлийн түвшин	4.9	3.1	5.8	5.0	6.4

ХҮСНЭГТ 3. ТӨВИЙН БҮСИЙН АЙМГУУДЫН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ

Аймаг нэр	Ажиллах хүч, мян.хүн					Ажиллах хүчнээс гадуурх хүн ам, мян.хүн				
	2019	2020	2021	2022	2023	2019	2020	2021	2022	2023
БҮГД	217.9	199.5	181.5	183.7	181.6	116.8	115.8	130.7	137.5	126.6
Говь-сүмбэр	8.1	7.5	7.2	5.7	5.9	2.7	3.5	3.7	5.3	5.3
Дархан-Уул	42.8	37.8	37.2	33.9	30.7	29.3	28.1	26.9	29.7	29.9
Дорноговь	32.9	29.3	26.4	27.3	32.0	14.9	13.4	17.9	20.3	17.4
Дундговь	23.2	22.2	23.3	24.9	17.8	7.8	9.4	9.2	9.5	10.4
Өмнөговь	32.5	30.2	28.1	31.5	34.9	13.3	11.8	17.9	13.2	15.1
Сэлэнгэ	37.7	28.6	24.0	23.4	20.2	29.5	31.5	34.5	36.7	33.3
Төв	40.8	43.9	35.2	37.0	40.1	19.3	18.1	20.6	22.9	15.2

ХҮСНЭГТ 4. АЖИЛЛАГЧДЫН ТОО, эдийн засгийн салбарын ангиллаар

Салбар	2019	2020	2021	2022	2023
БҮГД	22 040	21 463	21 966	23 674	16 623
Хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй	14 740	13 888	15 600	16 095	5 999
Уул уурхай, олборлолт	477	41	225	98	577
Боловсруулах үйлдвэр	464	377	859	482	628
Барилга	134	209	296	257	259
Цахилгаан, хий, уур агааржуулалт, усан хангамж	675	544	249	7	797
Бөөний болон жижиглэн худалдаа	1 311	1 264	854	1 531	946
Зочид буудал, зоогийн газар	57	199	86	71	423
Тээвэр, агуулах, холбоо	24	36	31	297	297
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	661	572	182	186	352
Төрийн удирдлага батлан хамгаалах үйл ажиллагаа	1 088	1 477	498	2 193	1 809
Боловсрол	1 293	1 463	1 588	1 461	2 435
Эрүүл мэнд, нийгмийн халамж	442	302	875	293	789

**ХӨДӨЛМӨРИЙН САЛБАРЫН ТАНИЛЦУУЛГА-2023**

Бусад

641

1 091

623

702

1 312

ХҮСНЭГТ 5. АЖИЛЛАГЧДЫН ТОО, НАСНЫ БҮЛГЭЭР, сүүлийн 5 жилээр

НАСНЫ БҮЛЭГ	2019	2020	2021	2022	2023
БҮГД	22 040	21 463	21 534	23 674	16 623
15-19	577	281	381	665	217
20-24	1 166	2 378	1 351	1 716	1 015
25-29	2 011	1 740	3 093	1 995	1 269
30-34	1 664	2 959	2 127	2 273	1 640
35-39	3 984	3 002	3 423	2 518	2 400
40-44	3 227	1 745	2 810	3 886	2 740
45-49	2 924	2 653	2 219	3 866	3 361
50-54	3 201	2 645	2 475	2 561	1 644
55-59	1 204	1 687	2 066	1 541	1 685
60-64	1 114	1 537	1 175	1 612	596
65-69	402	498	154	586	33
70+	565	339	260	455	23

ХҮСНЭГТ 6. ХӨДӨЛМӨРИЙН ДУТУУ АШИГЛАЛТ

Үзүүлэлтүүд	2020	2021	2022	2023
Нийт хөдөлмөрийн дутуу ашиглалт	956	1 724	1 879	1 398
Ажилгүй хүн	696	1 343	1 256	1 132
Цаг хугацаанаас хамаарсан бүрэн бус хөдөлмөр эрхлэгч	24	84	45	39
Боломжит ажиллах хүч	236	297	579	227

ХҮСНЭГТ 7. ТӨВИЙН БҮСИЙН АЙМГУУДЫН АЖИЛГҮЙДЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Аймаг нэр	Ажилгүй хүн, /мян. хүн/					Ажилгүйдлийн түвшин/хувиар/				
	2019	2020	2021	2022	2023	2019	2020	2021	2022	2023
БҮГД	16.6	13.5	18.5	10.5	10.7	7.6	6.8	9.9	5.7	5.9
Говь-Сүмбэр	0.8	0.7	0.8	0.3	0.4	10	9.9	12.7	5.5	6.5
Дархан-Уул	8	4.8	5.1	2.8	3.8	18.7	12.6	16.2	8.2	12.4
Дорноговь	1.2	1.2	0.4	0.3	1.1	3.9	4.1	2.7	0.9	3.6
Дундговь	1.1	0.6	1.7	1.3	1.1	4.9	3.1	5.8	5.0	6.4
Өмнөговь	1.9	1.7	1.7	2.1	1.7	6.0	5.6	6.9	6.0	4.9
Сэлэнгэ	1.7	3.1	7.4	1.8	2.0	4.7	10.9	24.8	7.8	9.7
Төв	1.7	1.2	1.1	1.9	0.6	4.1	2.8	2.1	5.3	1.4

ХҮСНЭГТ 8. АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД/үйл ажиллагааны нэгжээр/

Үзүүлэлт	ХАА-н салбар орсон			ХАА-н бус салбарт		
	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	7 334	4 428	2 906	1 350	698	652
Албан нэгж	458	122	336	458	122	336
Албан бус нэгж	6 876	4 307	2 569	892	577	315



ХҮСНЭГТ 9. АЛБАН БУС ХӨДӨЛМӨР ЭРХЛЭГЧИД/үйл ажиллагааны салбараар/

Салбар	2020	2021	2022	2023
Бүгд	15 167	16 638	17 059	7 334
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт	13 833	15 600	15 851	5 983
Уул уурхай, олборлолт	10	0	71	0
Боловсруулах үйлдвэрлэл	200	130	190	277
Усан хангамж; бохир ус зайлуулах систем, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0	20	0	0
Барилга	134	276	130	120
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	428	265	428	209
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	23	0	57	127
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	154	0	57	370
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	0	9	0	64
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	0	0	15	0
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	0	0	6	11
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	0	0	0	0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	385	339	253	171

ДҮГНЭЛТ

Хөдөлмөр эрхлэлтийн үзүүлэлтүүд нь хүн амын насны бүтэц, боловсролын байдлаас шууд хамаардаг бөгөөд хүн амын амьжиргааны түвшин, төрөлт, гэрлэлт, шилжих хөдөлгөөн зэрэг хүн амын үзүүлэлтүүдэд тодорхой нөлөө үзүүлдэг байна.

Ажиллах хүч өмнөх оны мөн үеэс 7.2(28.8%)мянгаар, ажиллагчид 7.0(29.8%) мянгаар, ажилгүй хүн 0.1(9.8%) мянгаар буурсан байна.

Ажиллагчдын 36,1 хувь нь хөдөө аж ахуйн тэр тусмаа мал аж ахуйн салбарт ажиллаж байгаа нь эдийн засгийн бусад дэд салбарыг хөгжүүлэх, аж үйлдвэр тэр дотроо боловсруулах үйлдвэрийн салбарыг түлхүү хөгжүүлэх шаардлагатайг харуулж байна. Аймгийн ажиллагчдын 7.5(45.3%) мянга нь эрэгтэйчүүд, 9.1(54.7%) мянга нь эмэгтэйчүүд байна.

Нийт ажиллагчдын 36.1 хувийг хөдөө аж ахуйн салбарт, 3.5 хувийг уул уурхай, олборлолт, 3.8 хувийг боловсруулах салбарт, 1.6 хувийг барилгын салбарт, 4.8 хувийг цахилгаан, дулаан эрчим хүчний салбарт, 5.7 хувийг бөөний болон жижиглэн худалдааны салбарт, 2.5 хувийг зочид буудал, зоогийн газрын салбарт, 1.8 хувийг тээвэр холбооны салбарт, 2.1 хувийг санхүү болон даатгалын үйл ажиллагааны салбарт, 10.9 хувийг төрийн удирдлага батлан хамгаалахын салбарт, 14.6 хувийг боловсролын салбарт, 4.7 хувийг эрүүл мэнд, нийгмийн халамжийн салбарт, 7.9 хувийг бусад салбарт ажиллагсад тус тус эзэлж байна.

Ажиллах хүчний оролцооны түвшин нь хөдөлмөрийн насны хүн амын хэдэн хувийг ажиллах хүчин эзэлж байгааг харуулдаг үзүүлэлт юм. Улсын ажиллах хүчний оролцооны



түвшин 57.6 хувь байгаагаас манай аймаг 5.5 нэгж хувиар их байна. Өмнөх оны мөн үеэс 9.4 нэгж хувиар өссөн буюу 63.1 хувьтай болсон нь 2023 онд ажиллах хүчний оролцоо нэмэгдсэн байна.

Ажилгүйдлийн түвшний улсын дүн 5.4, төвийн бүсийн дүн 5.9 байна. Аймгийн дүн 6.4 байгаа нь улсын дүнгээс 1.0 нэгж хувиар, бүсийн дүнгээс 0.5 нэгж хувиар их байна. Ажилгүйдлийн нэгж хувиар хамгийн өндөр нь Дархан-Уул аймаг 12.4, хамгийн бага нь Төв аймаг хамгийн бага 1.4 байна.

Дундговь аймгийн нийт төрийн албан хаагчид 3329 байгаагийн 899(27.0%) нь эрэгтэй, 2430(73.0%) нь эмэгтэй албан хаагчид байна. Насны ангиллаар авч үзвэл, 15-24 хүртэл насныхан 7.0 хувь, 25-34 насныхан 31.0 хувь, 34-44 насныхан 29.0 хувь, 45-54 насныхан 24.0 хувь, 55-59 насныхан 7.0 хувь, 60, түүнээс дээш насныхан 2.0 хувийг эзэлж байна.

Мэдээлэл авах холбоосууд:

<http://www.dundgovi.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2025 оны 6 дугаар сарын 25



Дундговь аймгийн Статистикийн
хэлтсийн

Дарга: Б.Энхтуяа

Утас: (976)-70593777

Танилцуулга бэлтгэсэн:

Мэргэжилтэн

Утас:

(976)70593715

Д

Г.Ариунжаргал